



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 1/382

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол болон "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан Хэрлэн сумын 1 дүгээр баг, Тэмүүжингийн гудамж, Л-39 байрлах 2645 м² газрыг, төрийн үйлчилгээний зориулалтаар "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар"-т 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын эзэмшиж байгаа газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 82 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Хэнтий аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар

Аймгийн Засаг даргын 20¹⁸ оны 11
Дугаар сарын 12 өдрийн 1/32 тоот
захирамжийн хавсралт
захирамжийн газар Баярхүү

Нэгж талбарын дугаар: 2311034296

Хуулийн этгээдийн нэр: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Баярхүү

Ашиглалтын төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 4186192

ХАЯГ: Аймаг/Хот:Хэнтий
Гудамж:

Сум/Дүүрэг: Хэрлэн
тоот: Л-39


Баг/Хороо: 1-р баг, Хэрлэн

Кадастрын муж: 110


Орчны тойм:

Орчны тойм:

Координатын систем:
WGS84 / UTM 49N
EPSG: 32649



Масштаб = 1:5000



Зургийн масштаб = 1:500 (1 сантиметрт 5 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2018-11-16

Талбайн хэмжээ: 2645 квадрат метр

Зураг хэвлэсэн:Н.Болор-Эрдэнэ
(Кадастрын мэргэжилтэн)
Хянасан:Дарга
(Д.Баярхүү)

